



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан



Монгол Улсын Их Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан байна.

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 421

Улаангом


Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралт, Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах” нийцлийн аудитын тайланг (УВА-2024/06-ШТА-НА) хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Т.Намжил нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	4
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-6
Ахлах аудитор Т.Намжил	Бүлэг 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна	7
Аудитор Т.Амармэнд Б.Нямбуу	1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу?	7
	1.2. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.	7-8
2024 оны 7 дугаар сар	1.3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.	8-9
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 29,859.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	10
	2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 29,859.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.	10-13
	2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.	13-14
	2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.	14
Хаяг: Увс аймаг дахь Төрийн Аудитын газар Улаангом сум 3 баг аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Дүгнэлт	15
	Холбогдох байгууллагын санал	16
	Аудитын газраас өгөх тайлбар	17
	Зөвлөмж	18

Товчилсон үгийн тайлал:

УВА	Увс аймаг
ШТА	Шууд тайлагнах аудит
НА	Нийцлийн аудит
УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын Сонгуулийн хороод, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн газар, холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу батлагдсан хөтөлбөрийн хүрээнд аудитыг хийж баталгаажуулсан.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль,
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Монгол улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/45 дугаар тушаалаар аймаг, нийслэлийн сонгуулийн зардлын төсвийг баталж 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 3/695 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Үүнд Увс аймгийн 20 сонгуулийн хороо, 93 ажлын хэсэгт нийт 975,677.3 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилжээ.

Мөн Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт УИХ-ын сонгуульд 32,180,300.0 мянган төгрөг, Засгийн газрын 2024 оны 200 дугаар “Хөрөнгө гаргах тухай” тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас сонгууль зохион байгуулахад шаардлагатай нэмэлт санхүүжилт 8,826,530.5 мянган төгрөг, УБЕГ-ын төсөвт 3,039,033.8 мянган төгрөг, ЦЕГ-ын төсөвт 1,460,075.3 мянган төгрөг тус тус баталсан байна. Үүнээс аймгийн Цагдаагийн газарт 46,018.0 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтэст 92,962.0 мянган төгрөг хуваарилсан байна.

БҮЛЭГ 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон уу?

Орон нутагт хамааралгүй байна.

1.2. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-д “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Аймаг, нийслэлийн сонгуулийн зардлын төсөв батлах тухай” А/45 дугаар тушаал гаргасан байна. Уг тушаалын хавсралтаар Увс аймгийн 20 сонгуулийн хороо, 93 ажлын хэсэгт нийт 975,677.3 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна.

Журмын 2.2-д “Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардал хуваарилна” гэж заасны дагуу дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

		/Мянган.төгрөг/
№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардал	14,691.2
3	МТБ, даамлын сургалтын зардал	21,390.0
4	Бичиг хэргийн зардал	15,010.0
5	Шуудан холбооны зардал	17,800.0
6	Унааны зардал	76,860.0
7	Санал авах байр бэлтгэх зардал	28,830.0
8	Сурталчилгааны зардал	8,000.0
9	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолтын зардал	59,320.0
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0
11	Шуурхай багийн зардал	2,130.0
12	Томилолтын зардал	14,558.1
13	Болзошгүй зардал	24,180.0
14	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	566,104.0
15	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	73,304.0
16	Хоолны зардал	51,900.0
	ДҮН	975,677.3

/Эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын тушаал/

Журмын 2.3-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах байдлаар хуваарилна” гэж заасны дагуу Увс аймгийн Сонгуулийн хорооны даргын “Санхүүжилт хуваарилах тухай” 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 04 дүгээр, 5 дугаар сарын 29-ний өдрийн 05 дугаар, 6 дугаар сарын 21-ний өдрийн өдрийн 07 дугаар, 07 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр захирамжуудаар тус тус хуваарилсан байна. Үүнд:

/Мянган төгрөг/

Д/д	Сумын нэр	Санал авах байр тохижуулах зардал	Бичиг хэргийн зардал	Шуудан холбооны зардал	Унааны зардал	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал	Хоол	НДШ	Болзошгүй зардал	Нэмэлт санхүүжилт	Нийт дүн
1	Баруунтуруун	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
2	Бөхмөрөн	645.0	510.0	600.0	2,590.0	17,600.0	1,600.0	2,112.0	200.0	600.0	26,457.0
3	Давст	645.0	510.0	600.0	2,590.0	17,600.0	1,600.0	2,112.0	200.0	600.0	26,457.0
4	Завхан	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
5	Зүүнговь	1,075.0	750.0	900.0	3,990.0	31,900.0	2,900.0	3,828.0	400.0	600.0	46,343.0
6	Зүүнхангай	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
7	Малчин	860.0	630.0	750.0	3,290.0	22,000.0	2,000.0	2,640.0	300.0	600.0	33,070.0
8	Наранбулаг	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
9	Өлгий	860.0	630.0	750.0	3,290.0	22,000.0	2,000.0	2,640.0	300.0	600.0	33,070.0
10	Өмнөговь	1,075.0	750.0	900.0	3,990.0	25,300.0	2,300.0	3,036.0	400.0	600.0	38,351.0
11	Өндөрхангай	1,075.0	750.0	900.0	3,990.0	25,300.0	2,300.0	3,036.0	400.0	600.0	38,351.0
12	Сагил	1,075.0	750.0	900.0	3,990.0	30,800.0	2,800.0	3,696.0	400.0	600.0	45,011.0
13	Тариалан	1,075.0	750.0	900.0	3,990.0	31,900.0	2,900.0	3,828.0	400.0	600.0	46,343.0
14	Түргэн	645.0	510.0	600.0	2,590.0	20,900.0	1,900.0	2,508.0	200.0	600.0	30,453.0
15	Тэс	2,150.0	1,350.0	1,650.0	7,490.0	59,400.0	5,400.0	7,128.0	900.0	600.0	86,068.0
16	Ховд	860.0	630.0	750.0	3,290.0	22,000.0	2,000.0	2,640.0	300.0	600.0	33,070.0
17	Хяргас	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
18	Цагаанхайрхан	860.0	630.0	750.0	3,290.0	26,400.0	2,400.0	3,168.0	300.0	600.0	38,398.0
19	Улаангом	2,795.0	1,710.0	2,100.0	9,590.0	77,000.0	7,000.0	9,240.0		600.0	110,035.0
	Нийт дүн	19,995.0	14,010.0	16,800.0	74,410.0	562,100.0	51,100.0	67,452.0	6,200.0	11,400.0	823,467.0

/Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын захирамж /

1.3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- 10.2.1.сонгогчийг бүртгэх, түүнийг таньж оруулах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, тээвэрлэх, даатгал хийлгэх зардал, лицензийн төлбөр;
- 10.2.2.сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, түүнийг цахим хуудаст байршуулах, хэвлэх, хүргэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;
- 10.2.3.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, холбоо, унаа, томилолтын зардал;
- 10.2.4.улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны сургалт зохион байгуулах, түүнтэй холбогдон гарах бусад зардал;
- 10.2.5.сонгогчийг бүртгэх техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын ажилтны томилолт, унааны зардал, техник тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий мэдээллийн технологийн шуурхай багийн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардал;
- 10.2.6.онцгой нөхцөл байдал үүссэн үед гарч болзошгүй зардал;
- 10.2.7.сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах бусад зардал.

Дээрх заалтын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсөв”-ийг баталсан байна. Үүнд:

/Мянган.төгрөг/

№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	61,287.5
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	6,026.5
3	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардал	15,812.0
4	Сонгогчдын бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	9,836.0
	ДҮН	92,962.0

/Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал/

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр тушаалын хавсралтаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийх зардалд 5,480.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

10.3.1.саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх үеийн хамгаалалт, санал авах байр болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах, дүн дамжуулах үеийн хамгаалалт, техник хэрэгсэл, шатахууны зардал;

10.3.2.цагдаагийн алба хаагчийн томилолт, унаа, мөнгөн урамшуулал, хоолны зардал.

Дээрх заалтын дагуу Цагдаагийн ерөнхий газрын санхүү, ар талын албаны 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 16/1983 дугаар албан бичгээр “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсөв”-ийг хуваарилсан байна. Үүнд:

/Мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Хуваарилсан төсөв
1	Хоолны зардал	27,648.0
2	Шуудан холбооны зардал	12,050.0
3	Дотоод албан томилолт	4,320.0
4	Шатахуун	2,000.0
	ДҮН	46,018.0

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын даргын албан бичиг/

**БҮЛЭГ 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын
Төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж,
үлдэгдэл 29,859.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.**

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 29,859.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсвийн зарцуулалт зардлын зүйл ангиллаар харуулбал дараах байдалтай байна.

/Мянган. төгрөг/

№	Зардлын нэр	Аймгийн нийт дүнгээр		
		Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалтын зардал	14,691.2	14,324.5	366.7
3	МТБ, даамлын сургалтын зардал	21,390.0	21,242.0	148.0
4	Бичиг хэргийн зардал	15,010.0	15,006.0	4.0
5	Шуудан холбооны зардал	17,800.0	16,800.0	1,000.0
6	Унааны зардал	76,860.0	76,453.1	406.9
7	Санал авах байр бэлтгэх зардал	28,830.0	28,830.0	-
8	Сурталчилгааны зардал	8,000.0	5,761.6	2,238.4
9	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх ачаа, томилолтын зардал	59,320.0	48,446.1	10,873.9
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0		1,300.0
11	Шуурхай багийн зардал	2,130.0	2,100.0	30.0
12	Томилолтын зардал	14,558.1	9,383.8	5,174.3
13	Болзошгүй зардал	24,180.0	21,342.8	2,837.2
14	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	566,104.0	560,974.2	5,129.8
15	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	73,304.0	73,304.0	-
16	Хоолны зардал	51,900.0	51,550.0	350.0
	Зарцуулалтын дүн	975,677.3	945,818.1	29,859.2
	Сум төвлөрүүлсэн орлого		4,689.4	- 4,689.4
	Аймаг төвлөрүүлсэн орлого		24,352.0	- 24,352.0
	Нийгмийн даатгалын газраас төвлөрүүлсэн орлого		817.8	- 817.8

/Эх сурвалж: Сонгуулийн хороодын анхан шатны баримт/

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.2-д Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна” гэж заасан байхад Тариалан, Завхан, Бөхмөрөн, Сагил, Өмнөговь, Улаангом сумдаас бусад сумдын сонгуулийн хорооны дарга нь нягтлан бодогч томилсон шийдвэр гаргаагүй байна.

Цаашид журамд заасны дагуу тушаал гарган нягтлан бодогч томилон ажиллах чиглэлийг сумдын сонгуулийн хороодод хүргүүлэхийг зөвлөмж болгов.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.6-д “Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна” гэж заасныг зөрчин Завхан сумын Сонгуулийн хорооны 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолоор хэсгийн хорооны 7 хүнд 4,200.0 мянган төгрөгийн урамшуулал, хоолны зардлыг давхардуулан олгож, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 462.0

мянган төгрөг төлсөн байсныг аудитын явцад залруулж буцаан төвлөрүүлж зөрчлийг арилгав.

Мөн аймаг, сумдын сонгуулийн хороод Нийгмийн даатгалын газарт 817.8 мянган төгрөг илүү шилжүүлснийг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Нийгмийн даатгалын газар аймгийн Сонгуулийн хорооны дансанд буцаан шилжүүлсэн байна. Аймгийн Сонгуулийн хороо дээрх үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 04/1116 дугаар албан бичигт “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар бүх шатны сонгуулийн хэсэг, хороонд ажиллахаар томилогдсон иргэнийг тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, эрүүл мэндийн даатгалд даатгуулж, түүнд олгосон урамшууллаас ажил олгогч 12 хувийн болон даатгуулагч 11.3 хувийн төлөх хувь хэмжээгээр, нийт 23.3 хувиар шимтгэл ногдуулан төлж, даатгуулагчийн төрлийн “76001” кодоор тайлагнана” гэж заасан байхад Түргэн сумын сонгуулийн хороо нь Сонгуулийн хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд техникийн даамал нийт 38 хүнд 20,900.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийн 2,361.7 мянган төгрөгийг суутган тооцоогүй, мөн Бөхмөрөн сумын сонгуулийн хороо урамшуулал олгохдоо даатгуулагчаас 11.5 хувиар тооцож 35.2 мянган төгрөг илүү суутгасан байна.

Дээрх зөрчилд холбогдуулан хяналт шалгалт хийж хуулийн хэрэгжилтийг хангуулж хамтран ажиллах тухай Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 306 дугаар албан бичгийг аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүллээ.

Мөн Түргэн сумын сонгуулийн хороо нь Сонгуулийн хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд техникийн даамал нийт 38 хүнд урамшуулал олгохдоо Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй дүнгээс ашгийн татвар суутгаснаас 236.2 мянган төгрөгийн татвар илүү суутгасан, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт “Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ” гэж заасныг зөрчин Бөхмөрөн сумын Сонгуулийн хороо нь хорооны гишүүд, хэсгийн хорооны гишүүд, техникийн даамал нийт 32 хүнд 17,600.0 мянган төгрөгийн урамшуулал олгохдоо хувь хүний орлогын албан татварын 640.0 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Дээрх зөрчилд холбогдуулан хяналт шалгалт хийж хуулийн хэрэгжилтийг хангуулж хамтран ажиллах тухай Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 307 дугаар албан бичгийг аймгийн Татварын газарт хүргүүллээ.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.8-д “Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчин

Бөхмөрөн сумын сонгуулийн хороо санал авах байр тохижуулах зардлаас 269.5 мянган төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан байна.

Цаашид журмыг мөрдөж ажиллахыг зөвлөв.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн А/24 дүгээр тушаалын хавсралтаар 92,962.0 мянга, 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр тушаалын хавсралтаар 5,480.0 мянга, нийт 98,346.5 мянган төгрөгийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилсныг дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:

/Мянган төгрөг/				
№	Зардлын зүйл анги	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	61,287.5	61,286.4	1.1
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэх зардал	6,026.5	6,026.5	-
3	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах зардал	15,812.0	15,812.0	-
4	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	9,836.0	9,760.0	76.0
5	Тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардлын төсөв	5,480.0	5,461.6	18.4
Нийт дүн		98,442.0	98,346.5	95.5

/Эх сурвалж: аймгийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын тушаал, анхан шатны баримт/

Дээрх хүснэгтээс харахад аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан 98,442.0 мянган төгрөгийн зардлаас 98,346.5 мянган төгрөгийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1-10.2.7 дахь хэсэгт заасны дагуу зарцуулж 95.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу хэсгийн хороодод ажилласан сумын бүртгэгч нарт урамшуулал олгоогүй байна.

Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 16/1983 дугаар тушаалаар 46,018.0 мянган төгрөгийг санал авах байрны хамгаалалт, дотоод албан томилолт, тээвэр шатахуун, цагдаагийн албан хаагчийн холбоо, хоолны зардалд захиран зарцуулах эрхийг Увс аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн байна. Хуваарилсан зардлыг батлагдсан төсвийн дагуу аймгийн ИТХ-ын сонгуулийн санал авах байрны хамгаалалтад ажилласан 94, саналын хуудас, санал авах төхөөрөмж хадгалах байрны хамгаалалтад ажилласан 19, гэмт хэрэг, зөрчил гомдол, мэдээллийг шалгаж шийдвэрлэх алба хаагч 11, сонгуулийн үйл ажиллагааны үед эргүүлд ажиллах албан хаагч 40, шуурхай штабт ажиллах албан хаагч 7, санал авах байранд нэмэлтээр ажиллуулах албан хаагч 8, замын хөдөлгөөн зохицуулалтад ажилласан албан хаагч 7, бусад томилгоот 3, нийт 189 албан хаагчдын томилолт, хоол, шуудан холбоо, унааны зардалд зарцуулсан байна.

Увс аймгийн хэмжээнд 20 сонгуулийн хороо, 93 хэсгийн хорооны санал авах байрны хамгаалалтад нийт 94 алба хаагчдыг томилон, 8 алба хаагчийг нөөцөөр ажиллуулсан байна.

Батлагдсан санхүүжилтээс хоолны зардалд 25,968.0 мянга, шуудан холбооны зардалд 12,050.0 мянга, шатахууны зардал 2,000.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 4,320.0 мянга, нийт 44,338.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

/Мянган.төгрөг/

Д/д	Зардал	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Дотоод албан томилолт	6,000.0	4,320.0	1,680.0
2	Тээвэр шатахуун	2,000.0	2,000.0	0
3	Хоол хүнс	25,648.0	25,968.0	0
4	шуудан холбоо	12,050.0	12,050.0	0
	Нийт дүн	46,018.0	44,338.0	1,680.0

/Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, анхан шатны баримт/

Аймгийн Цагдаагийн газарт хуваарилагдаж ирсэн зардлаас 1,680.0 мянган төгрөгийн хэмнэлт гарсныг буцаан төвлөрүүлсэн байна.

2.2. Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.4-д “Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нягтлан бодогч нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө” гэж заасан байна.

Мөн журмын 4.5-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооны ирүүлсэн тайланд төлөвлөгөө гүйцэтгэл дараах байдалтай байна.

/Мянган төгрөг/

Д/д	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баруунтуруун	38,398.0	38,398.0	-
2	Бөхмөрөн	26,457.0	26,457.0	-
3	Давст	26,457.0	26,457.0	-
4	Завхан	38,398.0	33,736.0	4,662.0
5	Зүүнговь	46,343.0	46,343.0	-
6	Зүүнхангай	38,398.0	38,398.0	-
7	Малчин	33,070.0	33,070.0	-
8	Наранбулаг	38,398.0	38,393.9	4.1
9	Өлгий	33,070.0	33,069.9	0.2
10	Өмнөговь	38,351.0	38,351.0	-
11	Өндөрхангай	38,351.0	38,351.0	-
12	Сагил	45,011.0	45,011.0	-
13	Тариалан	46,343.0	46,343.0	-
14	Түргэн	30,453.0	30,453.0	-
15	Тэс	86,068.0	86,068.0	-
16	Ховд	33,070.0	33,070.0	-
17	Хяргас	38,398.0	38,374.9	23.2
18	Цагаанхайрхан	38,398.0	38,398.0	-
19	Улаангом	110,035.0	110,035.0	-
20	Аймаг	152,210.3	127,858.3	24,352.0
21	Нийгмийн даатгалын газраас төвлөрүүлсэн		(817.8)	817.8
	Нийт дүн	975,677.3	945,818.1	29,859.2

/Эх сурвалж: Сонгуулийн хороодын анхан шатны баримт/

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9-д “Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хороо 24,352.0 мянган төгрөг, Завхан сумын сонгуулийн хороо 4,662.0 мянга, Хяргас сумын сонгуулийн хороо 23.2 мянга, Наранбулаг сумын сонгуулийн хороо 4.1 мянга, Өлгий сумын сонгуулийн хороо 0.2 мянга, Нийгмийн даатгалын газраас Сонгуулийн хороодын илүү шилжүүлсэн нийгмийн даатгалын шимтгэлийн 817.8 мянга, нийт 29,859.2 мянган төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10-д Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороодын сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

Цаашид журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлэн ажиллах, салбар хороодод чиглэл хүргүүлэхийг зөвлөв.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг сонгуулийн зардлын санхүүжилт олгох бүрд ирүүлсэн байна. Үүнд:

- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 3/229 дүгээр бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 3/290 дүгээр бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 3/373 дугаар бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны 2024 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 3/472 дугаар бичиг
- Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 3/562 дугаар бичиг

Мөн аймгийн сонгуулийн хорооны 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар албан бичгээр сумдын сонгуулийн хорооны төсвийн хуваарийн тухай тайлбарыг хүргүүлсэн байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.
2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан байна.
3. Тариалан, Завхан, Бөхмөрөн, Сагил, Өмнөговь, Улаангом сумдаас бусад сумдын Сонгуулийн хорооны дарга нь нягтлан бодогч томилсон шийдвэр гаргаагүй байна.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2315, Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2024.07.29 № 33

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит
сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх аудитын дүгнэлттэй санал нэг байна.

ДАРГА  Г.БОЛОР-ЭРДЭНЭ



**Холбогдох байгууллагын ирүүлсэн
саналд өгөх тайлбар**

Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 33 дугаар бичгээр тайлангийн төсөлтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор
дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Сонгуулийн хорооны дарга Г.Болор-Эрдэнэ танаа

1. Журамд заасны дагуу тушаал гарган нягтлан бодогч томилох чиглэлийг
салбар хороодод хүргүүлэх.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Т.НАМЖИЛ

АУДИТОР:

Т.АМАРМЭНД
Б.НЯМБУУ

ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

М.БАТ-АМГАЛАН

